

Баян-өлгий аймаг Толбо сум, Толбо нуур, Бүргэдтэй анчин
Bayan-Ulgii Province: Tolbo Sout, Lake Tolbo, Eagle Hunter



“Монголын тухай романс өгүүллэг бичихээр энд нэг сар амьдрах нь миний мөрөөдөл юм”

ГЭРЭЛ ЗУРГИЙГ: Г.БАГЦУХ

My dream is

to have an opportunity to do a writing residency for a month there to write a Mongolian romance novel



Вики Чонг нь Сингапурт ажиллаж амьдардаг зохиолч юм. Тэрбээр Лондонгийн их сургуулийн Голдсмитсийн коллежид бүтээлч бичих арга зүйн (creative writing) чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан.

Vicky Chong is a writer based in Singapore. She graduated with Master of Arts - Creative Writing from Goldsmiths' College, University of London.

МИАТ компанийн олон улсын болон дотоодын нислэгүүдэд тараагддаг “Монголика” сэтгүүл нь Монгол Улсаа дэлхийн уншигчдад таниулах зорилгоор олон жилийн турш амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нислэгийн багийн арвин туршлагатай “гишүүн” болжээ. “National Geographic”, “Cosmopolitan Монгол” сэтгүүлүүдийг эрхлэн гаргаж байсан, олон улсын хэвлэл мэдээллийн тавцанд туршлагажсан хамт олноос бүрдсэн “Монголика”-гийн баг Монгол Улсынхаа сэтгэл татам, өвөрмөц чанарыг гадаад ертөнцөд таниулах ирмүүн хүсэл дүүрэн ажиллаж байна. Дугаар бүрдээ бид дэлхийн уншигчдыг Монголд өрнөж буй онцлох хөгжил дэвшилтэй танилцуулах нийтлэл бэлтгэдэг. Үүгээр бид эх газрын эрс тэс уур амьсгалын дор нүүдэлчин өв уламжлалаа тууштай хадгалж үлдэнгээ хурдтайгаар хөгжиж буй улс орныхоо мөн чанарыг харуулахыг зорьж, Монголын сайхныг нүдээр үзэж, мэдэрсэн жуулчдын уншууртай ярилцлагуудаар дамжуулан уг зорилгоо биелүүлдэг. Энэ дугаарын эрхэм зочны ярилцлагыг хүргэе.

"Mongolica" magazine, available in the international and local flight services of MIAT, is a seasoned and complimentary publication with a wealth of experience dedicated to showcasing Mongolia to a global audience. Crafted by a team with extensive international media experience, including contributions to National Geographic and Cosmopolitan Mongolia magazines, "Mongolica" aspires to promote the unique allure of Mongolia abroad. In each edition, the magazine regularly features a column designed to acquaint foreign readers with the dynamic developments taking place in Mongolia. It strives to capture the essence of a country progressing rapidly while steadfastly preserving its nomadic heritage and enduring the mainland's extreme climate. This is achieved through insightful interviews with tourists who have experienced the charm of Mongolia first-hand. In this regard, we extend our interview questions to you, inviting you to participate as a valued guest in this enlightening column.



Баян-Өлгий аймаг Улаан хус сум Алтай Таван Богд
Bayan-Ulgii Province: Ulaan Khus Soutn, Altai Tavan Bogd

Таны иогтой холбоотой аяллаас ярилцлагаа эхэлье. Биед гарах үр дүнгээс гадна иог нь бие сэтгэлийн холбоосыг сайжруулж, тэнцвэрт байдал, бие сэтгэлээ зөв захирахад нөлөөлдөг гэдэг. Энэхүү өөрчлөгч талаас нь та дэлгэрүүлэн ярьж болох уу?

Таны хэлсэн нь иогоор хичээллэхийн туйлын зорилго мөн боловч Сингапурын иогийн студиуд ихэвчлэн биеийн байрлалд гол анхаарлаа хандуулж, илүү хүчирхэг, уян хатан биетэй болох дасгалыг суралцагчид хийдэг. Би нурууны өвчнөө анагаахаар 2007 онд иогоор хичээллэж эхлээд миний биед гарч буй эрс өөрчлөлтийг хараад эргэлт буцалтгүй татагдсан.

Би 2023 оны нэгдүгээр сард иогийн багшийн 200 цагийн сургалтад сурч, гэрчилгээ авсныхаа дараа үргэлжлүүлэн Patanjali Yoga Sutra дээр онлайн хичээл хийсэн. Тэр үед иог нь оюун санаагаа тогтворжуулах техник болохыг олж мэдсэн юм. Бясалгал нь гол төлөв шашинтай холбоотой байдаг бол олон үндэстэн, олон соёл, олон шашин нэг дор цогцлон буй Сингапурт иог нь биеийн дасгалд тооцогддог. Тиймд Сингапур болон барууны орнуудад иогийг дасгал хөдөлгөөн гэдэг талаас нь хардаг. Надад иог өөрийн дотоод руу өнгийж, биеийн болон сэтгэл зүйн талаасаа өөрийнхөө талаар сурах дасгал болдог. Иогоор хичээллэж эхлэхээс өмнөх үетэй харьцуулбал илүү хайхрамжтай, хариу үйлдэл үзүүлэхээсээ өмнө анзаардаг, илүү талархдаг хүн болсон.

Delve into your journey with yoga. Beyond physical benefits, practicing yoga is believed to deepen the connection between the body and the mind, fostering equilibrium and mastery of both. Can you elaborate on this transformative aspect?

While that is the ideal objective for yoga, many yoga studios in Singapore focus mainly on the physical asanas (poses) where students practise yoga to get physically stronger and more flexible. I started my yoga journey in 2007 to cure my backache and was hooked when I noticed a transformation in my body.

In January 2023, I enrolled in the 200-hour yoga teachers training certification (YTTC) course and subsequently did an online course on Patanjali Yoga Sutra. That was when I realised what yoga was - a technique to still the mind. Meditation is often associated with religion but yoga is promoted as a secular physical activity in Singapore, a country that is multiethnic, multicultural, and multireligious. Thus, the practice of yoga in Singapore, as well as in the West, associates yoga with physical exercise.

For me, yoga practice is a time to go inward, to learn about myself physically and psychologically. I have become more mindful, slower to react, and more appreciative than before I started yoga practice.


ГЭРЭЛЗУРГИЙГ: Г.БАГСУХ

Хүн төрөлхтний эволюци хувьсал нь хөгжил тав тухыг эрэлхийлж ирсэн хэдий ч бүтээхүйн үндэс нь байгалиас улбаатай. Олон мянган жилийн туршид байгальтай зохицон амьдарсан хүмүүс энэхүү суурь үнэнтэй нягт холбоотой аж төрж ирсэн байдаг. Энэ хүрээнд Монгол орны уур амьсгал, байгаль, хүн зоны талаар танд ямар бодол төрж байсан бэ, Монгол дахь туршлагаасаа юуг суралцсан бэ?

Нэг орой Баянзагийн Улалзах цонж дээр очиж үзээд гэр камп руугаа ирэх замд манай жолооч төөрчихсөн. GSP, интернэт сүлжээ байхгүй тэр шөнө жолоочид оддын байршлаар баримжаалан жуулчны баазаа олж байгааг хараад гайхширсан. Тэр туршлага “Азийн шилдэг богино өгүүллэгүүд 2023”-т багтсан “Төөрсөн нь” сэдэвт богино бичвэр болсон юм.

Монголд ирэхдээ аяллын агентлагтайгаа зөвлөж, Google-ээс мэдээлэл авсан нь хангалттай байгаагүй. Би 10 дугаар сард агаарын температур цельсийн 18 хэм байна гэж тооцоолсон байсан. Баян-Өлгий рүү явахдаа бэлтгэлээ сайн хангаагүйгээ мэдэж, тэнд өндрөөс болж бие эвгүйрч, хоолны хордлогод орж, их хүйтэнтэй нүүр тулсан. Азаар өвлийн хувцас нэмж аваад дараа өдөр нь бүргэдийн баяр руу явж чадахаар болов.

Хотоос гараад оччихдог хөдөөгүй дэлхийн олон улсаас ирсэн хүмүүс зэрэгцэн аж төрдөг хотоос ирсэн надад нүүдэлчдийн гэрт зочлох нь нүд нээсэн шинэ туршлага болсон юм. Миний орсон гэрт тухайн айл гурван үеэрээ амьдарч, унтаж, гал тогоо нь хүртэл гэр дотроо багтсан байхыг харсан. Гэрээс гарахад өргөн уудам, цэлгэр тал байлаа. Хахир өвлийг давахын тулд тэр айл хэдхэн долоо хоногийн дотор гэрээ ачаад нүүгээд явах боломжтой гэдгийг төсөөлөхөд ч бэрх байв. Тухайн айлын амьдралд надаас хэдхэн эгч эмэгтэй гол үүрэгтэй, эрх мэдэлтэй байгааг харсан нь мөн намайг гайхшируулсан.



Чөлөөт цагаараа тэр иогоор хичээллэж, бүтэн сайнг цэцэрлэгт хүрээлэнг найзуугтайгаа гар гээрээ тогтоож, иогоор хичээллэх эвент зохион байгуулдаг.

In her spare time, she practices yoga, and handstand and conducts Sunday yoga in the park for her friends.



Human evolution is entwined with a quest for development and comfort, yet the roots of creation trace back to nature. Those who have harmonized with nature for millennia remain closely tethered to this fundamental truth. In light of this, how did you perceive Mongolia's climate, nature, and its people, and what energies did you draw from these experiences?

While we were returning to our ger camp after visiting the Flaming Cliffs one evening, our drivers got lost in the Gobi Desert. That night, with no GPS or internet connection, I was amazed to see how the drivers used the stars to navigate and find the way to our lodge. That experience resulted in my short story Lost, which is published in the anthology, The Best Asian Short Stories 2023.

Our trip to Mongolia was ill-prepared despite having consulted our travel agent and Google. We were assured that the temperature would be a mild 18 degrees Celsius in October. I was under-packed for Ugli and we arrived suffering from altitude sickness, food poisoning and extreme cold. Thank goodness we were able to buy emergency winter clothes and recovered sufficiently the next day for the eagle festival.

Coming from a cosmopolitan city with no hinterland, the visit to the nomad family in their fully functional ger was an eye-opener. The ger was cozy, a single tent that served as living, sleeping, and kitchen quarters for a three-generation family. Outside the ger, the land is vast and barren. It is difficult to imagine that in a few weeks, the family would have to pack up the ger to move in order to escape the harsh winter. I watched the matriarch of the family, who was only slightly older than me, I was in awe of her tenacity in holding on to this way of life.



“Uber-ийн жолооч” хэмээх богино хэмжээний өгүүллэгээрээ 2018 онд Ник Хоакины нэрэмжит Ази Номхон галайн уран зохиолын шагнал хүртсэн.

Short story The Uber Driver won a prize in the 2018 Nick Joaquin Literary Awards Asia-Pacific.

Филиппины “Бизнес моль” сайтад түүний богино хэмжээний гурван бүтээлийг нийтэлж байв.

She had three short stories published in Business Mirror, Philippines.

Монгол руу аялах шийдвэрийг яагаад гаргасан тухайгаа хуваалцана уу. Юу танд Монголоор аялах санаа өгч, та энэ сэтгэл татам газрын талаар анх яаж олж мэдэж байв? Аяллаа та нэг бүрчлэн нарийн төлөвлөсөн үү? Монголын талаарх таны төсөөлөл бодитоор ирж үзсэний дараах сэтгэгдэл хоёр хэр зөрүүтэй байсан бэ?

Mongolia Nomadic Voyage-ын зар санамсаргүйгээр фэйсбүүк дээр гарч ирсэн. Говьд гэрт хонох, амьдрах гэдэг онцгой санагдсан. Бид өмнө нь Сахарын цөлөөр аялж, зах хязгааргүй цөлд дурлаад байсан юм. Би аяллын компанитай холбогдоход Соёлоо гэдэг эзэн нь Сингапурт байж таараад бид уулзсан. Түүний авчирсан чамин тансаг гэрүүдтэй гялгар брошурьг хараад бид Монгол явахаар бүрэн шийдсэн.

Монгол дахь аялал тань ямар байсан бэ?

Соёлоо таван хүнтэй манай аяллын багт зориулан хоёр машинтай аяллыг зохион байгуулсан. Бид шувуу сонирхогчид бөгөөд бүргэдийн баярыг үзэхийг хүсч байгаагаа, бас Монгол орны өвөрмөц сонирхолтой байдлыг мэдэрмээр байгаагаа хэлсэн. Бид стандарт төлөвлөгөөтэй байсан боловч Соёлоо бидэнд зориулан төлөвлөгөөг өөрчилж, хотоор бага аялж, шувууны зураг авахаар байгалийн цогцолборт газруудаар түлхүү явахаар болсон юм. Санамсаргүйгээр Баян-Өлгийд бүргэдийн баяр үзэхээр ирсэн Сингапурын 10 шувуу сонирхогчтой таарсан. Тэднээс гадна Сингапурын автомашины холбоогоор дамжуулан 30 жолооч Улаанбаатараас Баян-Өлгий рүү автомашинаар гарсан байв. Мөн Сингапурын их сургуулийн 12 оюутнаас бүрдсэн баг мөн аялж явахтай таарсан.



Share the origins of your decision to travel to Mongolia. What prompted the idea, and how did you first learn about this fascinating destination? Was the journey meticulously planned? Reflect on the disjunction, if any, between your preconceived notions of Mongolia and the reality you encountered upon arrival.

A post by Mongolia Nomadic Voyage popped up randomly on Facebook and I was fascinated by the idea of living in a ger in the middle of the Gobi Desert. We had camped at the Sahara Desert and fell in love with the vast expanse of the desert. I contacted the company and Soylo, the owner, happened to be in Singapore and we met up. He had brought along glossy brochures detailing luxurious gers with ensuite and we were sold.

Detail your travels within Mongolia.

Soylo had organized a private tour with two 4WDs for our group of five. We were birders eager to experience the Eagle Festivals but we also wanted to learn about this exotic country. Although we followed the standard itinerary, Soylo was able to customised our trip such that we did fewer city tours and explored more national parks for bird photography. Coincidentally, in Ugli, we met up with a group of ten birders from Singapore who were also there for the Eagle Festival. That was in addition to a convoy of over thirty drivers from the Singapore Automobile Association who had driven from Ulaan Baatar to Ugli, plus another group of twelve university students from Singapore.

Биг шувуу сонирхогчид бөгөөд бүргэдийн баярыг үзэхийг хүсч байгаагаа, бас Монгол орны өвөрмөц сонирхолтой байдлыг мэдэрмээр байгаагаа хэлсэн.

We were birders eager to experience the Eagle Festivals but we also wanted to learn about this exotic country.

ГЭРЭЛЗУРГИЙГ: Michael Toh

ГЭРЭЛЗУРГИЙГ: Г.Батсүх




Очсон газруудаас хамгийн онцгой нь аль нь байсан бэ, танд мартагдахгүй сэтгэгдэл төрүүлсэн газар бий юу?

Аль ч улсад очсон онгоцноос буухад угтах цаг агаар, миний эргэн тойронд нутгийн хэлээрээ ярих хүмүүс, алсад харагдах тухайн орны байгалийн тогтоц, машинаар өнгөрсөн рүү аялчих шиг эгэл жирийн хүмүүсийн хэрхэн амьдарч байгааг ажиглан харах нь миний сэтгэлд тод үлддэг. Хот доторх байдал аль ч хотод очсон тэр бүр ялгаатай байдаггүй ч дөрвөн дугуйтай автомашинаар хотоос гаран очиход газарт хаа сайгүй цэг хатгасан мэт харагдаж байсан дугуй гэрүүд миний сэтгэлийг татсан. Гэрүүд надад цар тахлын хөл хорионоос шалтгаалаад гурван жил хойшлуулсан аяллаа хийж, жинхнээсээ Монголд ирсэн байгааг минь сануулсан. Гэрт хононо гэхээс их догдолсон. Жуулчны бааз ч говьд тансаг гэрт хонуулж урмыг минь хугалаагүй. Нүүдэлчин айлын жинхэнэ гэрт ороход хүндлэх сэтгэл төрсөн. Айлууд яаж гэрээ буулгаж ачаад, улирлаар нүүдэллэдэг юм бол гэж гайхаж байлаа.

What were the standout destinations, and did any place leave an indelible mark on you?

As I first step out of the airport in any of the countries I've visited, I'm first fascinated by the change in weather, the languages I hear being spoken around me, the landscape in the distance, and how ordinary people go about their lives as my car drives past. The sights in most cities are rarely different but I was charmed as I traveled in my 4WD by the ubiquitous circular tents dotting the landscape. The gers were a nudge for me to be fully present, a reminder that I was finally in Mongolia, three years after the world went into a pandemic lockdown which delayed this trip. I couldn't wait to sleep in a ger and my lodge did not disappoint with the promise of glamping in the Gobi Desert. Thus, for me to visit a nomadic family and see an actual living ger was humbling. I couldn't fathom how the family could dismantle their home and move with the seasons.



Мухар шивэрт, Өмнөговь аймаг
Mukhar Shivert, Umnugobi Province

ГЭРЭЛ ЗУРГИЙГ: Б.Эрдэнэбулган

Тэрбээр мөн “Penguin Random House”-аас эрхлэн гаргасан “Чимээ шуугуан болон бусад түүх” номын зохиолч юм.

She is the author of *Racket and Other Stories*, published by Penguin Random House.



Түүний талаар илүү ихийг мэдэхийг хусвэл дараах цахим хуудсаар зочлоорой: vickychong.sg

You can connect with her at her website: vickychong.sg

ГЭРЭЛ ЗУРГИЙГ: Michael Toh



Монголд зочлох үеэрээ очсон хамгийн сэтгэл татам эсвэл хамгийн сэтгэл хөдөлгөм газар юу байсан бэ? Монголд байхдаа хамгийн баяр хөөртэй байсан үеэ дурсвал ямар мөчид та аз жаргалтай байсан бэ?

Бүргэдийн баярт явахын өмнөх өдөр зочид буудлаасаа Баян-Өлгий рүү бүргэдтэй анчин айлд очихоор аялах үедээ бид бутанд бие засахаар нуурын ойролцоо зогссон. Бие засахаар суух үед морин төвөргөөн сонстож, бушуухан өмдөө татсан (гурван давхар!). Кинон дээр гардаг шиг дөрвөн сайхан дээлтэй залуу бүгд гар дээрээ бүргэд суулгачихсан морьтой ирж харагдсан бөгөөд гүехэн усан дээгүүр морьд давхихад киноны хөгжим шиг дуу чимээ гарч байсан. Бид өмнө нь бүргэдчин харж байгаагүй болохоор онцгой санагдаж, камер руугаа гүйцгээсэн. Тэд сайхан зантай хүмүүс байж таараад бидэнд өөрсдийнхөө зургийг авах боломж олгон камер руу харж зогссон. Бидний аяллын хамгийн дурсамжтай үе тэр байсан.

Өөр сэтгэл хөдлөм зүйл гэвэл бидний машины урдуур янгир давхиж, Гурван сайханы байгалийн цогцолборт газрын Ёлын аманд ховор шувууд болох хажир тас, нөмрөг тас харсан нь байв.

Identify the most enchanting or emotionally resonant place you visited during your time in Mongolia. Recall the pinnacle of joy during your stay in Mongolia what moment encapsulated the essence of happiness for you?

On the day before the Eagle Festival, as we were traveling from our hotel in Ugli to visit an eagle hunter's family, we stopped by a beautiful lake for a toilet break in the bush. Just as I was conducting my business, I heard galloping sounds and quickly pulled up my pants (three layers!) In the distance, as if I was watching a surreal movie, four handsome horsemen dressed in the finest del appeared, each with a majestic eagle perched on the forearm, the horses' hooves splashing on the shallow water providing the accompanying soundtrack. We were awestruck as we had never seen an eagle hunter before and scrambled for our cameras. They were very nice and obligingly posed for us. That was the most memorable experience of our trip.

Other exciting adventures included spotting ibexes crossing in front of our path, the rare Himalayan Griffon and Cinereous Vultures at Yol Valley in Gurvansaikhan National Park.



Алтай Таван Богд, Баян-Өлгий аймаг
Altai Tavan Bogd, Bayan-Ulgii Province

Энэ онцгой газраар хөндлөн гулд аялахад танд ямар нэг бэрхшээл тулгарсан уу. Монгол хүмүүс, тэдний амьдралын хэв маягийн талаарх сэтгэгдлээ хуваалцана уу. Аяллыг адал явдал, танилын хүрээгээ тэлэх боломж гэдэг талаас нь харвал та Монгол дахь аяллынхаа үеэр хэчнээн найзтай болж чадсан бэ?

Бид чадварлаг хөтөч, жолооч нартай явсан тул газардаагүй. Өлгийд очоод гурвуулаа өвдсөн байхад манай хөтөч Сараа бидэнд их тус болсон. Бүргэдийн баяр дээр Сараа өндөр учраас дэгдээхийнүүдээ харж буй эх шувуу шиг бидний харах боломжийг хязгаарлахаар оролдсон хүмүүстэй учраа олж чадсан. Бид Монголоос зөвхөн сайхан дурсамжуудаар зогсохгүй түүний нөхрийн зурсан зургуудтай буцацгаасан.

Share any challenges you faced while traversing this unique terrain. Provide your insights and impressions of the Mongolian people and their way of life. Recognizing travel as an adventure and an avenue for forging connections, how many friendships have you formed during your time in Mongolia?

We were well taken care of by our wonderful guide and drivers. When three of us were very sick upon arriving in Ugli, Sara, our guide ensured our comfort. At the Eagle Festival, a tall woman, Sara was like a mother hen looking after her brood of chicks and chased away the others who tried to steal our viewing spots. We left Mongolia not only with wonderful memories of our stay, but each of us received a painting done by her artist husband.

ГЭРЭЛЗУРГИЙГ: Б.Эрдэнэбулган



Зохиолчийн богино хэмжээний өгүүллэгүүдийг та “Азийн шилдэг богино өгүүллэгүүд” 2021, 2022, 2023; “Хүүгээ илгээх захидал болон огны харагдах байдал”; “Алдагдсан холбоос”; “Сампан завины цуврал” 1,2; “Сингапурын шилдэг богино өгүүллэгүүд” 6-р цувралаас олж уншиж болно.

Her short stories are found in the anthologies: *The Best Asian Short Stories 2021, 2022 and 2023, Letter to my Son and A View of Stars, Missed Connection, Sampan Volume 1 and 2, Best New Singapore Short Stories, Volume 6.*

Энэ ярилцлагын сүүлийн асуултаар таныг Монголд дахин ирэхээр төлөвлөж буй эсэхийг сонирхож байна. Хэрвээ ирэх төлөвлөгөөтэй бол дараагийн удаад юу хийхээр төлөвлөж байна вэ? Соёлоо намайг өвлийн Монголыг үзээрэй гэж уриад сэтгэл татагдам адал явдалтай төлөвлөгөө гаргасан ч би татгалзсан. Зураг дээр гол төлөв гардаг шиг тал ногоорох үед зуны Монголд дахин ирмээр байна. Монголын романс өгүүллэг бичихээр энд нэг сар амьдрах нь миний мөрөөдөл юм. Эсхүл иогоор хичээллэдэг бүлэг хүмүүсийг энд авчирмаар байна. Магадгүй миний мөрөөдөл биелэх байх.

Lastly, do you harbor plans for a return to Mongolia? If so, what experiences do you anticipate and activities do you plan to undertake on your next visit?

Soylo invited me to experience a white, winter Mongolia and I reluctantly declined despite the attractive adventure he painstakingly curated. Instead, I would love to see Mongolia in summer when the prairie is lush and green, as is often depicted in photos. My dream is to have an opportunity to do a writing residency for a month there to write a Mongolian romance novel. Or to lead a group of yoga practitioners there for a yoga retreat. Perhaps my dream might just come true.